



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2021 оны 05 сарын 19 өдөр

Дугаар А/2449

Арвайхээр

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.2, 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн "Ногоон байгууламжийг нэмэгдүүлэх-Орчны бохирдлыг бууруулах" жил болгон зарлах тухай 07/04 тогтоол, иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн "Аймгийн 2022 оны төсөв батлах тухай" 07/08 дугаар тогтоолын 4 дүгээр хавсралтын 4 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1."Ногоон байгууламжийг нэмэгдүүлэх-Орчны бохирдлыг бууруулах" зорилтот жилийн хүрээнд Арвайхээр сумын хог хаягдлын тогтвортой менежментийг бий болгох зөвлөх үйлчилгээний зардалд 18,000,000 (арван найман сая) төгрөгийг зарцуулсугай.

2.Дээрх зардалд шаардлагатай 18,000,000 (арван найман сая) төгрөгийг аймгийн зорилтот жилийн зардлаас олгохыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Ц.Ганболд)-д зөвшөөрсүгэй.

3.Арвайхээр сумын хог хаягдлын тогтвортой менежментийг бий болгох зөвлөх үйлчилгээний гэрээг хууль, тогтоомжийн дагуу аж ахуйн нэгжтэй байгуулж, үр дүн гаргаж ажиллахыг Арвайхээр сумын Засаг дарга (Б.Ганбат), ажлын гүйцэтгэлд хяналт тавьж, хамтран ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга (Ч.Гүнсэнхорол), аймгийн Засаг даргын дэргэдэх Байгаль орчин, аялал жуулчлалын газрын дарга (Г.Баясгалан) нарт тус тус даалгасугай..

ЗАСАГ ДАРГА

А.ИШДОРЖ



6222 11 0535